

Ажлын хуудас №3

Энд дарж бичлэгийг үзнэ үү.

Даалгавар-1 Сар  яагаад өөр өөр хэлбэртэй харагддаг юм бол?

Таамаглацгаая:

Батын таамаглал:

Өдрөөс хамаарч
сарны хэлбэр өөр
өөр байж магадгүй.

Болдын таамаглал:

Нарны тусгал
болон байрлалаас
хамаардаг байх.

Уянгын таамаглал:

Дэлхий ба сарны
хөдөлгөөнөөс
болдог байх.


Чиний таамаглал:

.....
.....

Даалгавар-2 Сар өөрөөсөө гэрэл гаргадаг билүү? Хэрвээ сар гэрэлтдэг байсан бол өдөр бүр өөр өөр хэлбэрээр харагддаг юм болов уу?

.....
.....

Даалгавар-3 Туршилтын үр дүнг ярилцаж, дараах асуултуудад хариулъя.



1. Нар болон дэлхий хоёрын хооронд сар байрласан тохиолдолд дэлхийгээс сар харагдахгүй байна. Яагаад юм бол?
.....
2. Харин нар болон сар хоёрын хооронд дэлхий байрлаж байхдаа сар бидэнд яаж харагдсан бэ?
.....
3. Ямар тохиолдолд зүүнээс гэрэлтсэн тал болон тэргэл сар, ямар тохиолдолд баруунаас гэрэлтсэн тал болон тэргэл сар дэлхийд харагдсан бэ?

.....

.....

Сар дэлхийг аль зүгт
тойрдог юм бэ?

- A. Цагийн зүүний эсрэг
Б. Цагийн зүүний дагуу

Сарны хэлбэр яагаад өөрчлөгддөг вэ?

- a. Дэлхий тэнхлэгээ эргэдэгтэй холбоотой.
b. Сар дэлхийг тойрдогтой холбоотой.
c. Дэлхий нарыг тойрдогтой холбоотой.
d. Сар нарыг тойрдогтой холбоотой.

Сарны үзэгдэх хэлбэр өдрөөс өдөрт өөр өөр байдаг нь , ,
..... –ийн байрлалтай холбоотой байна.